



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 06 сарын 26 өдөр

Дугаар 309

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.5, 6.4.4, 6.4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Үйлдвэрлэл урлалын Политехник коллежийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Мэргэжлийн хяналтын газрын улсын ахлах байцаагчийн 2017 оны 02-07-092/1188 дугаар дүгнэлтээр ашиглах боломжгүй нь тогтоогдсон нийт 374,729,400.00 (гурван зуун далан дөрвөн сая долоон зуун хорин есөн мянга дөрвөн зуун) төгрөгийн балансын үнэ, 18,736,470.00 (арван найман сая долоон зуун гучин зургаан мянга дөрвөн зуун далан) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан 1 ширхэг барилгыг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Үйлдвэрлэл урлалын Политехник коллежийн захирал Б.Даваажавд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;


2.3.Энэ тогтоолын биелэлтийн дүнг 2018 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

2.4.Үл хөдлөх хөрөнгийг акталж буулгах, газар (чөлөөлөгдөх талбай)-ыг албан ажлын зориулалтаас өөрөөр ашиглахгүй байх;

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА


ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА



Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА





Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2018 оны 06 дугаар сарын 26 -ны өдрийн  
 дугаар тогтоолын хавсралт

Үйлдвэрлэл урлалын Политехник коллежийн үндсэн  
 хөрөнгөд бүртгэлтэй актлах барилгын жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Байршил	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Үйлдвэрлэл урлалын Политехник коллежийн Автын мэргэжлийн дадлагын барилга	1936	Сүхбаатар дүүрэг, 6 дугаар хороо, модон бамбай хучилттай, 1 давхар, 279,08м2	374.729.400.00	18.736.470.00	355.992.930.00
	Нийт дүн			374.729.400.00 (гурван зуун далан дөрвөн сая долоон зуун хорин есөн мянга дөрвөн зуун)	18.736.470.00 (арван найман сая долоон зуун гучин зургаан мянга дөрвөн зуун далан)	355.992.930.00 (гурван зуун тавин таван сая есөн зуун ерэн хоёр мянга есөн зуун гучин)